



**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

## **МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК**

Танилцуулга  
2019 оны 9 дүгээр сар


Улаанбаатар  
2019



## 1 Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 14.0 хувиар өсч 20.4 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 7.1 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 3.6 нэгж хувийг гадаад валютын харилцах, 2.5 нэгж хувийг төгрөгийн харилцах, 1.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлсэн байна.


Зураг 1-1: M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 14.0%-иар нэмэгдсэн байна.



Эх сурвалж: Монголбанк

Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 42.8 тэрбум төгрөг буюу 0.2 хувиар буурчээ.

Зураг 1-2: M2 мөнгө өмнөх сараас 42.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.




Эх сурвалж: Монголбанк

Тодруулбал санхүүгийн байгууллагын төгрөгийн хадгаламж, хувийн байгууллагын гадаад валютын

харилцах, улсын байгууллагын төгрөгийн харилцах буурчээ. Харин улсын байгууллагын гадаад валютын харилцах, хувийн байгууллагын төгрөгийн хадгаламж, бусад санхүүгийн байгууллагын төгрөгийн харилцах нэмэгдсэн байна.

Нийт хадгаламжийн хэмжээ 13.7 их наяд төгрөг байгаа ба 85.1 хувь буюу 11.7 их наяд төгрөг нь иргэдийн, 14.9 хувь буюу 2 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 21.3 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 21.5 хувийг, байгууллагын хадгаламжийн 20.3 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 1-3: M2 мөнгө өмнөх сараас 42.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.




Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 17.6 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 2.8 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал M2 мөнгөний өсөлтийн 23.7 нэгж хувийг

ГЦА, -9.7 нэгж хувийг ДЦА бүрдүүлж байна. ГЦА-ын өсөлтөнд Төв банкны гадаад цэвэр актив нэмэгдсэн нь нөлөөлсөн байгаа бол ДЦА буурсан нь Төв банкнаас Засгийн газарт өгөх өглөг нэмэгдсэн болон банкуудын зээл олголт буурсантай холбоотой байна.

Зураг 1-4: М2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.




Эх сурвалж: Монголбанк

## 2 Банкуудын зээл

### 2.1 Зээлийн өсөлт

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 11 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 14.6 хувиар өсч 9.3 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 7 хувиар өсч 8.5 их наяд төгрөгт тус тус хүрчээ.

Зураг 2-1: Нийт зээлийн үлдэгдэл 18.0 их наяд төгрөгт хүрч жилийн 11.0 хувиар өсөв.




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн 12.6 хувь буюу 2.3 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын зээл байна.

### 2.2 Зээл олголт, эргэн төлөлт

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 129.6 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 6.4 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Зураг 2-2: Тайлант сард 1,493 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1,610 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдлөө.




Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон зээлийн 9.7 хувь буюу 144.6 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

### 2.3 Чанаргүй зээл

Чанаргүй зээлийн 82.7 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 78.3 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Зураг 2-3: Чанаргүй зээл нь нийт зээлийн 10.9%, хугацаа хэтэрсэн зээлийн 5.5%-тай тэнцэж байна.



Тайлбар: \* үйл ажиллагаа явуулж буй 13 банкаар  
Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээлийн үлдэгдэл 1,966.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 59.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн 19.6 хувь нь гадаад валютаар олгогджээ.

Чанаргүй зээлийн 22.2 хувийг уул уурхай, 20.6 хувийг боловсруулах, 11.8 хувийг барилга, 8.3 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл эзэлж байна.

Зураг 2-4: Чанаргүй зээлийн 82.7% хувийн байгууллагын, 16.3% иргэдийн зээл байна.




Эх сурвалж: Монголбанк

### 2.4 Хувийн байгууллагын зээл

Тайлант сард хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 130 тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлэв.



Эх сурвалж: Монголбанк

Үүнд, худалдааны салбарын зээл 55.2 тэрбум, уул уурхайн салбарын зээл 17.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь

нөлөөлжээ. Тайлант сард хувийн байгууллагад 660.1 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 18.3 хувь буюу 120.9 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-6: Худалдаа, уул уурхай, боловсруулах салбарт дийлэнх зээл олгогдсон байна.




\*Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд. Эх сурвалж: Монголбанк

### 2.5 Иргэдийн зээл

Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 3.9 тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнээс цалин тэтгэврийн зээл 45.6 тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 2-7: Иргэдийн зээлийн 38% (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 34%-ийг цалин тэтгэврийн зээл бүрдүүлэв.



Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн автомашины зээл 14.7 тэрбум, худалдааны зээл 10.6 тэрбум, төгрөгөөр тус тус буурсан. Харин ипотекийн зээл 14.1 тэрбум төгрөгөөр, бусад хэрэглээний зээл 31 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.



Тайлант сард иргэдэд 769.7 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 3.1 хувь буюу 23.6 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-8: Хадгаламж барьцаалсан, цалин тэтгэвэр, картын зээл ихэнх хувийг эзэлж байна.




\*ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.

Эх сурвалж: Монголбанк

## 2.6 ЖДҮ-ийн зээл

ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 4,020 тэрбум төгрөгт хүрснээс 32.1 хувийг худалдааны салбарт, 14.9 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 13.4 хувийг барилгын салбарт, 8.2 хувийг үйлчилгээний салбарт тус тус олгосон байна.

Зураг 2-9: ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН болон иргэдэд олгосон зээлийн 32 хувийг салбар бүрдүүлж байна.




Эх сурвалж: Монголбанк

## 3 Ипотекийн зээл

2019 оны 9 дүгээр сарын байдлаар 95,187 зээлдэгч нийт 4.5 их наяд төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 70,910 зээлдэгч 3.4 их наяд төгрөгийн зээл авчээ.


Зураг 3-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 4.2%-д хүрэв.



Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 74.3 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 20.2 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 5.5 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна. Нийт ипотекийн зээлийн 17.0 хувь буюу 767 тэрбум төгрөгийн зээл орон нутагт ногдож байна.

Зураг 3-2: Нийт зээлийн 17% буюу 767 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна




Эх сурвалж: Монголбанк

Орон нутгийн ипотекийн зээл<sup>1</sup>-ийн 77.9 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 18.8 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 3.2 хувь нь бусад эх үүсвэрээр олгогдсон байна.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.3 хувь нь хэвийн, 2.7 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.0 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 60.1 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 38.2 хувийг хөтөлбөрийн зээл, 1.6 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Зураг 3-3: Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 10.9 тэрбум төгрөгөөр буурч, чанаргүй зээл 5.3 тэрбум төгрөгөөр өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

Тайлант сард 948 зээлдэгчид 67.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн шинээр олгосон бөгөөд үүний 44.6% хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.


Зураг 3-4: Тайлант сард шинээр 948 зээлдэгчид ипотекийн зээл шинээр олгожээ.



Эх сурвалж: Монголбанк

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурч 11.0 хувьд хүрсэн байна.

Зураг 3-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурчээ.



Эх сурвалж: Монголбанк


<sup>1</sup> Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

## 4 Хүү

### 4.1 Шинээр татсан хадгаламж


2019 оны 9 дүгээр сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 11.0 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурав. Гадаад валютын хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар өсч 5.8 хувьд хүрэв.

Зураг 4-1: Шинээр татсан хадгаламжийн хүү 0.6 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-2: Шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 11.3%, хугацаагүй хадгаламжийн хүү 6.3% байна.



Эх сурвалж: Монголбанк


### 4.2 Шинээр олгосон зээл

Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.9<sup>2</sup> хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурсан бол шинээр олгосон

<sup>2</sup> Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.


валютын зээл 0.1 нэгж хувиар өсч ЖДХ 9.9 хувьд хүрсэн байна.

Зураг 4-3: Шинээр олгосон зээлийн хүү 16.9% байна.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-4: Шинээр олгосон нийт зээлийн хүү өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк


Иргэдэд 769.7 тэрбум төгрөгийн зээл олгосноос дийлэнх нь буюу 68.8 хувь нь 2 жил хүртэлх хугацаатай байна.

### 4.3 Үлдэгдлээрх хадгаламж

Нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ 11.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурчээ. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.9 хувьтай байна. Хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ иргэдийн төгрөгийн хадгаламжийн хувьд 11.5 хувь, гадаад валютын

хадгаламжийн хувьд 5.0 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн хувьд 11.3 хувьтай байна.

Зураг 4-5: Үлдэгдлээр жигнэсэн хадгаламжийн хүү 11.5% байна.




Эх сурвалж: Монголбанк

#### 4.4 Хүүний зөрүү

Тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээл болон тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүүний зөрүү 2019 оны 9 дүгээр сарын байдлаар 6.7 нэгж хувьд хүрэв.

Зураг 4-6: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх оноос 0.6 нэгж хувиар өсчээ.




Эх сурвалж: Монголбанк

#### 4.5 Зээлийн үлдэгдэл

Төгрөгийн зээлийн үлдэгдэлд ЖДХ 16.9 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.8 хувьтай байна. Үүнээс

иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 17.8<sup>3</sup> хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 12.3 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.6 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.7 хувьтай байна. Нийт төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 4-7: Иргэдийн зээлийн үлдэгдлийн хүү 1.4 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийн дийлэнхийг 25-36 болон 37-60 сарын хооронд төлөгдөж дуусах зээлүүд эзэлж байна.

Зураг 4-8: Зээлийн үлдэгдэл, хугацаагаар



Эх сурвалж: Монголбанк

<sup>3</sup> Хөтөлбөрийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.




## 5 Инфляци

### 5.1 Улсын инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2019 оны 9 дүгээр сарын байдлаар жилийн 9 хувь, сарын инфляци 0.1 хувь буюу бараг өөрчлөлтгүй байна.

Зураг 5-1: Улсын жилийн инфляци 9 хувьтай байна.




Жилийн инфляцийг авч үзвэл хүнсний барааны үнийн өсөлт мах болон хүнсний ногооны үнийн өсөлтөөр тодорхойлогдож байгаа бол хүнснээс бусад барааны өсөлтөд хувцас, бөс бараа болон орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлт нөлөөлсөн байна.

### 5.2 Улаанбаатар хотын жилийн инфляци

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 9 дүгээр сарын байдлаар 10.5 байгаа ба 5.9 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 4.6 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд хувцас, орон сууцны урсгал засвартай холбоотой бараа, үйлчилгээ, хатуу түлшний үнийн өсөлт, хүнсний барааны бүлгийн үнэд махны үнийн өсөлт голлон нөлөөлжээ.


Зураг 5-2: УБ хотын жилийн инфляци 10.5 хувь



Тайлант сард УБ хотын хэмжээнд сарын инфляци 0.0 хувьтай байна. Годруулбал -0.1 нэгж хувийг хүнсний бараа, 0.1 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлт тайлбарлаж байна.

Хүнснээс бусад барааны үнэ өсөхөд голлон хатуу түлш, хувцас, бөс барааний үнийн өсөлт нөлөөлжээ. Харин хүнсний барааны үнэ буурахад хүнсний ногооны үнийн бууралт нөлөөлжээ.

Зураг 5-3: УБ хотын сарын инфляци өөрчлөлтгүй байна.




## 6 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

### 6.1 Ам.долларын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,667.21 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.2 хувиар чангарсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2,669.68 төгрөг байв.

Зураг 6-1: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт.




Эх сурвалж: Монголбанк

### 6.2 Хятадын юанийн ханш

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас чангарч 374.10 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 372.7 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 377.94 төгрөг байлаа.

Зураг 6-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт.



Эх сурвалж: Монголбанк